

2024 он 05 сар 01 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

Зээлийн гэрээ байгуулах, хөрөнгө барьцаалах тухай

“Говь” ХК болон “Таван Богд Холдингс” ХХК-ууд нь “Хас Банк”-тай зээлийн гэрээ байгуулах тухай асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалтуудыг тус тус үндэслэн “Говь” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. “Говь” ХК болон “Таван Богд Холдингс” ХХК-ууд нь дараах нөхцөлийн дагуу “Хас Банк”-тай “Ноолуур бэлтгэлд зориулан олгох зээл”-ийн гэрээ байгуулахыг зөвшөөрсүгэй. Үүнд:
 - 1.1. Зээлийн хэмжээ: 10,000,000,000 /арван тэрбум/ төгрөг
 - 1.2. Зээлийн хугацаа: 12 /арван хоёр/ сар
 - 1.3. Зээлийн хүү:
 - Төгрөгийн хүү жилийн 5.0 /таван/ хувь, зээлийн төлбөр (зээлийн үндсэн төлбөр эсвэл хүүгийн төлбөр)-ийг 90 болон түүнээс дээш хоногоор төлөөгүй, хугацаа хэтрүүлсэн болон гэрээнд заасан зөрчил гаргасан тохиолдолд зээлийн хүүгийн дэмжлэг цуцлагдаж, зээлийн хүү Банкны нийтэд зарласан Бизнесийн зээлийн хүү болох 24.0 /хорин дөрөв/ хувьд шилжих,
2. Зээлийн шугамын гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар “Говь” ХК-ийн Хавсралт №1-д заасан хөрөнгүүдийг барьцаалахыг зөвшөөрсүгэй.
3. Дээрх Зээлийн шугамын гэрээ, Барьцааны гэрээ, бусад холбогдох гэрээ, бичиг баримтад “Говь” ХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг тус компанийн Гүйцэтгэх захирал /Б.Амарсайхан/-д олгосугай.

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:



Б.АМАРСАЙХАН

Б.АМАРСАЙХАН

Д.ГЭРЭЛМАА

А.ЖАРГАЛМАА

Н.МӨНХБАТ

Ц.ОРГИЛБОЛД

Э.ПҮРЭВЛХАМ

Д.ХУЛАН

Д.ХҮРЭЛБААТАР